



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 7/388

Хэрлэн сум

Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Макс Майнд" ХХК-аас аймгийн Засаг даргад холбогдуулан Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан нэхэмжлэлд, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2.2, 28.2.3, 28.2.4, 28.2.5, 28.2.6 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ нарт олгож өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд аймгийн Засаг даргыг төлөөлж оролцохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА

